



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Гахайн гоц халдварт мялзан өвчнөөс  
урьдчилан сэргийлэх арга хэмжээг  
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.15, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 198 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны "Журам батлах тухай" 134 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зарим аймгийн нутаг дэвсгэрт илэрсэн гахайн гоц халдварт мялзан өвчин нийслэлийн нутаг дэвсгэрт тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гахайн аж ахуй эрхэлж байгаа болон гахайн мах, түүхий эдийг ашиглаж хоол үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулах, нийслэлийн авто тээврийн шалган бүртгэх товчоодыг түшиглэн нийслэлийн нутаг дэвсгэрт нэвтэрч буй бүх төрлийн тээврийн хэрэгсэлд 24 цагийн хяналт шалгалт, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Л.Гантөмөр/, Нийслэлийн Цагдаагийн газар /Д.Ядамдорж/, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газар /Д.Дашдорж/, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Нийслэлийн Мал эмнэлгийн газар /М.Адилбиш/ болон дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Энэ захирамжийн нэгдүгээр заалтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Онцгой байдлын газар /Ж.Чүлтэмсүрэн/-т даалгасугай.

3. Хяналт шалгалт, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс тухай бүрт санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т зөвшөөрсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НОГООН ХӨГЖИЛ,  
АГААРЫН БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
ОРЛОГЧ

Ж.БАТБАЯСГАЛАН



02010/...